



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Г “Монгол Улсын их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрэм”-д өөрчлөлт оруулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 27 дугаар 27.1.1 дэх заалт, “Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм”-ийн 4.4 дэх хэсэг, МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар тогтоол, МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын их сургуулийн захиргааны бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан “МУИС-ийн Удирдах зөвлөлийн дүрэм”-ийн 2.3 дахь хэсэгт “... Ректорын ажлын алба ...” гэснийг “... Захиргааны хариуцсан нэгж ...” гэж өөрчилсүгэй.
2. “МУИС-ийн Удирдах зөвлөлийн дүрэм”-ийн өөрчлөлтийг 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  X.БАТЖАРГАЛ

1424010076

МУИС-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр Монгол Улсын их сургууль (цаашид “МУИС” гэх)-ийн Удирдах зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Удирдах зөвлөл нь Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжчинч ухааны сайдын 2023 оны А/576 дугаар тушаалаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм” (цаашид “нийтлэг дүрэм” гэх), МУИС-ийн 5.2 дахь хэсэгт болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3. Удирдах зөвлөл нь үйл ажиллагаандaa хууль дээдлэх, эрх тэгш, ил тод, хамтран ажиллах, олон талын оролцоог хангах зарчмыг баримтална.

Хоёр. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

2.1. Удирдах зөвлөл Дээд боловсролын тухай хуулийн 26.3 дахь хэсэг, нийтлэг дүрэмд заасан удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хамаарах төлөөллийг бүрдүүлж ажиллана.

2.2. Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийн нийтлэг дүрмийг 2.3.1-т заасны дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.

2.3. Удирдах зөвлөлийн багшийн төлөөллийг үндсэн орон тооны багш нарын 50-аас доoshгүй хувийн ирцтэй хурлаас нууц санал хураалтын хэлбэрээр сонгоно. Захиргааны хариуцсан нэгж санал хураалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

2.4. Суралцагчийн төлөөлөл нь МУИС-ийн Оюутны холбоо-Оюутан Конгрессын тэргүүн байна.

2.5. Төгсөгчийн төлөөллийг төсөгчдийн нэгдсэн холбооны удирдлагын хурлаас сонгоно.

2.6. Ажил олгогчийн төлөөллийг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Холбооны гишүүн ажил олгогчдын төлөөллөөс тус тус нэр дэвшүүлж сонгоно.

2.7. Удирдах зөвлөл дэх багшийн нэг төлөөллийг сургуулийн Үйлдвэрчний Эвлэлийн гишүүн багш нарын төлөөллөөс нэр дэвшүүлж сонгоно.

Гурав. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа түүний хэлбэр

3.1. Удирдах зөвлөл хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаанд гишүүдийн 60-аас доoshгүй хувийн ирцтэй байх тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. Хэлэлцсэн асуудлаар олонхын саналаар шийдвэр /тогтоол/ гаргана.

3.2. Удирдах зөвлөлийн хуралдаанд гишүүд цахимаар оролцож болох бөгөөд гишүүдийн 40 хувиас хэтрэхгүй байна.

3.3. Удирдах зөвлөлийн дарга тогтоолд гарын үсэг зурж, МУИС-ийн тамгаар албажуулна.

3.4. Удирдах зөвлөлийн хурлыг жилд хоёроос доoshгүй удаа зохион байгуулна. Ээлжит бус хурлыг үүсгэн байгуулагчийн, Удирдах зөвлөлийн даргын, гурваас доoshгүй гишүүний саналаар зарлан хуралдуулж болно.

3.5. Удирдах зөвлөлийн дарга хурлыг ажлын гурваас доoshгүй хоногийн өмнө товлож, нарийн бичгийн дарга хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг гишүүдэд хүргүүлнэ.

3.6. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга МУИС-ийн захиргааны ажилтан байна. Хуралдаанд удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга саналын эрхгүй оролцно.

3.7. Удирдах зөвлөлийн хуралдааныг хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлыг Удирдах зөвлөлийн дарга сургуулийн Ректортой тохиролцон шийдвэрлэнэ.

3.8. Сургуулийн ректор, проректор болон багш, ажилтан, суралцаачийн төлөөллийг Удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр оролцуулан тайлбар, санал, хүсэлтийг давч болно.

3.9. Удирдах зөвлөл нь шаардлагатай тохиолдолд МУИС-ийн онцлогт нийцүүлэн тодорхой чиглэлээр туслах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

3.10. Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг хугацаанаас нь өмнө өндөрлөх үүрэгтэй татах асуудлыг Дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн нийтлэг дүрмээр зохицуулна.

Дөрөв. Удирдах зөвлөлийн чиг үүрэг

4.1. Удирдах зөвлөл нь Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна МУИС-ийн дүрэмд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. МУИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг хэлэлцэн батлах, өөрчлөх;

4.1.2. МУИС-ийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлт, бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэж батлах;

4.1.3. МУИС-ийн жилийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, гүйцэтгэл, зарцуулалтад хяналт тавих;

4.1.4. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандив тусламж авах журам тогтоох, зарцуулалтад хяналт тавих;

4.1.5. Сургалтын болон оюутны байрны төлбөр, оюутны үйлчилгээний зардлын хэмжээг тогтоох;

4.1.6. МУИС-ийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн үнэлж дүгнэлт гаргах;

4.1.7 МУИС-ийн Ректорын ажлын байрны тодорхойлолтыг батлах;

4.1.8. Нээлттэй сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ректорыг томилох, гэрээ байгуулах, ажлыг нь үнэлэх, гэрээг дүгнэх, чөлөөлөх.

Тав. Удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн эрх, үүрэг

5.1. Удирдах зөвлөлийн дарга, гишүүн нийтлэг дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна дараах эрх өдэлж, үүрэг хүлээнэ.

5.2. Хууль, дүрэмд заасан эрх, үүргээ үнэнч шударга байдлыг эрхэмлэн сургуулийн болон суралцагчийн нийтлэг эрх, ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх

5.3. Удирдах зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд оролцоог хангах, шийдвэр гаргахад санал өгөх

5.4. Удирдах зөвлөлийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэлтэй танилцах, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах.

Зургаа. Бусад

6.1. Удирдах зөвлөлийн бичиг хэрэг, үйл ажиллагааны зардлыг сургуулийн тухайн жилийн төсөвт тусгана.

6.2. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг харгалзан Удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний дүйцэх мөнгөн урамшууллыг хуралдаан тутамд олгоно.

6.3. Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох хууль, журмыг баримталж ажиллана.

---Оо---